

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXX (463)

2016

(61-75)

ХАРИЛЦАХ ҮЙЛИЙН ОНЦЛОГ, НИЙГМИЙН ҮҮРЭГ

Г. Буянтогтох *

Хүн насан турш, унтаа, сэрүүн аль ч цагт орчинтой байнга харилцан байж оршин тогтнодог бөгөөд амь, амилал хоёрын нэгдлээр арга билигт тулгуурлан бүтдэг тогтнох үйл явцыг үндэстний оршихуй, оршихуйн бусдаас ялгаран ондооших чадварыг арга, ухааныг билиг; хүний мөн чанар буюу үндэстний сэтгэлгээг оршихуйн амь, хэлийг оршихуйн амилал (бод бие), хэлний хам цагийн хэлбэрийг яриа, цуваа цагийн хэлбэрийг бичиг гэнэ.

Хүний харилцахуйг илрэх байдлаар нь хүрээлэн буй орчинтой зохилдох үйл буюу биеэр харилцах гадаад, дотоод үйл, ухамсарлан зохилдохуйн үйл буюу сэтгэлийн үйл, өгүүлэн илэрхийлэх үйл буюу хэлээр харилцах гадаад, дотоод үйл гэж хуваана.

Хэлээр харилцах үйлийн тухайд бол, анх, “Мич маягийн манай өндөр өвөг . . . хүн төлөвийг олж, . . . бие биедээ ямар нэгэн юм хэлэх хэрэгтэй болжээ. Хэрэгцээ нь ч эрхтнээ бий болгов. Тэгээд мичний хөгжөөгүй болхи төвөнх хэрэгцээний эрхээр нэг аялгуунаас нөгөө аялгуунд аажим боловч хэлбэрэлтгүй өөрчлөгдөн боловсорч, тасралтгүй шилжин хөгжсөөр, амны хөндийн эрхтнүүд ч тус тус ялгаатай авиаг дараа дараагаар дуудаж . . .” (Энгельс. х -76 - 78)¹ сурсан бөгөөд ингэхдээ үнэлэмжид тулгуурлан бүтдэг, ээлжээр өгүүлж харилцах, ээлжээр бус өгүүлж харилцах үндсэн хоёр зүйл харилцахуйг бүтээжээ.

Ярих, сонсох дараалсан хоёр юм уу хэдэн хүний хоорондын харилцах үйлийг ээлжээр өгүүлэх гадаад харилцахуй, нэг нь ярьж, бусад нь сонсох үйлийг ээлжээр бус өгүүлэх гадаад харилцахуй гэж нэрлэдэг. Хэлээр харилцах гадаад үйлийг, сэтгэлгээний ертөнцийн авиа тэмдгээр гүйцэтгэх аман; сэтгэлгээний ертөнцийн авиа бус, төгс, төгс бус угтат тэмдгээр гүйцэтгэх аман бус хэлбэрийн салшгүй нэгдэлд тулгуурлан бүтэх, улс орон даяар өдөр тутмын харилцааг залгуулж, нийгмийг амилуулж байгаа, бүгдэд ойлгомжтой хүртээмжтэй байх шаардлагад нийцсэн, бүх төрлийн ном зохиол, сонин хэвлэл, сэтгүүл товхимлын хэл болон Төр, Засгийн зарлиг шийдвэр, хууль тогтоомж, албаны бичиг баримтын хэл, бас

* МУИС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹Ф.Энгельс, Мич хүн болоход хөдөлмөрийн гүйцэтгэсэн үүрэг, “К.Маркс. Ф.Энгельс. Түүвэр зохиол”, 3-р боть.

сургууль, театр, радио, телевиз, хурал цуглааны хэлнээс бүрдэх Улсын албаны харилцахуй; нийгмийн тодорхой хэсэг, явцуу хүрээ, тухайлбал, сум, баг, хот айл, эсвэл, ажил мэргэжил, үйлс зорилго нэгтэй цөөн хүн ойлгож хэрэглэдэг нутгийн аялгуу, нэр томъёо, зохистой зохисгүй, өвөрмөц хэллэг зэргээс бүрдэх албаны бус харилцахуй хэмээн ангилан зааглах бөгөөд хам цаг буюу харилцах үйл болж буй цагт аман хэлбэр голлож, аман бус нь дагалддаг бол цуваа цаг буюу харилцах үйл болж өнгөрсөн цагт эсрэгээрээ байдаг. Харин, хэлээр харилцах дотоод үйл энэ хоёр цагийн аль алинд байна. Түүнчлэн, хэлээр харилцах дотоод харилцахуй зөвхөн өөртөө хандсан, ээлжээр өгүүлж харилцахуй мэт байдаг ч чухамдаа бол өөр рүү чиглэсэн харилцахуй, бусдад хандсан харилцахуйн аль аль нь болж байдаг бөгөөд дотоод харилцахуйд эргэцүүлэх, хүүрнэх өгүүлэхүй, гадаад харилцахуйд тайлбарлах, тоочих өгүүлэхүй голлож байдаг.

Утга, тэмдэг, хэрэглээ, соёлоос бүтдэг үндэстний сэтгэлгээ тухай тухайн үндэстний мөн чанар буюу оршихуйн үндэс; салшгүй холбоотой гадаад, дотоод харилцахуй энэ үндсийн үндэс болж, оршихуйг нь нөхцөлдүүлж байдаг бөгөөд хүний бие, хэл, сэтгэлийн бүх үйлийн мөн чанар, бод бие; оюуны ухамсарт үйлээр бий болсон үйл буюу хүсэхүй хийгээд үл хүсэхүйн утгыг илэрхийлэх үнэлгээг үнэлэмж; ертөнцийн юм, үзэгдлийн дүр зургийг тархиндаа буулган авч ухамсарлаад, шууд утгаар нэрлэснийг үндэстний сэтгэлгээний ертөнцийн утга; үндэстний сэтгэлгээний ертөнцийн утгыг тодорхой ухагдахуун болгож, гадаад дотоод харилцааг нь илтгэсэн хэлний нэгжийг үндэстний сэтгэлгээний ертөнцийн тэмдэг; үндэстний сэтгэлгээний ертөнцийн тэмдгийг хувиргаж, төрөл бүрийн харилцааны утга илтгэхийг үндэстний сэтгэлгээний ертөнцийн хэрэглээ; үндэстний сэтгэлгээний ертөнцийн тэмдгийг харилцааны тухайн орчинд оновчтой сонгон тааруулж, зохистойгоор хувирган хэрэглэхийг үндэстний сэтгэлгээний ертөнцийн соёл гэх ба үндэстний сэтгэлгээний ертөнцийн утга бодит үнэнд; тэмдэг хийсвэр ухагдахуунд; хэрэглээ, соёл хоёр санаа бодол илтгэн харилцах шаардлага, үнэлэмжид тус тус тулгуурлана. Дээр өгүүлсний дотроос, ертөнцийн дүр зургийг шууд оноон тэмдэглэсэн ухагдахуун - цөм утга; ертөнцийн дүр зургийн язгуур шинжийг шууд оноон тэмдэглэсэн ухагдахуун - гадаад цөм утга; ертөнцийн дүр зургийн язгуур шинжийг шууд оноон тэмдэглэсэн ерөнхий ухагдахуун - дотоод цөм утга; ертөнцийн дүр зургийн язгуур шинжийг шууд оноон тэмдэглэсэн тусгай ухагдахуун - дотоод мөнчанаарын цөм утга; ертөнцийн дүр зургийн язгуур шинжийг шууд оноон тэмдэглэсэн онцгой ухагдахуун - дотоод бүтцийн цөм утга; ертөнцийн дүр зургийг шууд бус оноон тэмдэглэсэн ухагдахуун - цөм бус утга; ертөнцийн дүр зургийг шууд бус, зэрэгцүүлэн оноон тэмдэглэсэн ухагдахуун - зэрэгцсэн цөм бус утга; ертөнцийн дүр зургийг шууд бус, угсруулан оноон тэмдэглэсэн ухагдахуун - эс зэрэгцсэн цөм бус утгаас бүрддэг сэтгэлгээний ертөнцийн утга бол харилцах үйлийн дотоод цөм, хүний амьд мэндийн баталгаа, үндэстэн угсаатны оршихуйн үндсийн үндэс болдог учраас түүнд хайхрамжгүй хандвал амархан эвдэрч сүйдэх маш эмзэг юм гэдгийг үе үеийн эрдэмтэн судлаач нар онцлон тэмдэглэж, “Хоосон амаараа биеэ эх оронч гэж сагсуураад байдаггүй, үнэн сэтгэлийнхээ голоос эх орондоо, чин зоригт баатар ард түмэндээ халуун хайртай хүн болгон ардынхаа

нандин сайхан хэлийг хайрлан энхрийлж үзэх ёстой” (Б.Ринчен)² гэх мэтээр сургасан байдаг.

Дорно, Өрнийн үе үеийн мэргэд хүнийг сэтгэлийн амьтан гэж тэмдэглэсээр ирсэн бөгөөд сэтгэл нь биеийн үйлд тулгуурласан хэлний үйлээр илэрдэг учраас хүний амьдралд хэл буюу харилцах үйл амин чухал үүрэгтэй. Харилцах үйл гэдэг сэрүүн тунгалаг аж төрж яваа тухайн хүн өөрөө учраас зан сэтгэлгээ, амь амьдрал нэгтэй олон хүний нэгдэл болсон үндэстний хэл гэдэг түүний оршихуй юм. “Хүн хэлээрээ, мал хөлөөрөө” гэсэн мэргэн сургаалын утгыг үүгээр ухаж болно.

Хүний мөнхийн эрмэлзэл тэмүүлэл, үүрдийн эрэл хайгуул бол амин зуулга, алдар нэр, амжилт бүтээл, эрх мэдэл, эрдэм мэдлэг, аз жаргал. Товчоор хэлбэл, амар амгалан. Амар амгалан ашдын, ашдын бус хоёр зүйл бөгөөд хүний туйлын хүсэл тэмүүлэл бол ашдын амар амгалан (төгс гэгээрэл). Ашдын амар амгаланг хүний нийгэм буюу орчлонгоос олох нэлээд бэрхшээлтэй, боломж байхгүй мэт санагдаж болох ч хүн насан туршийн бүх ухамсарт үйлээ түүний зүгт зүй зохисоор хандуулан зориулбал төгс гэгээрч, нэгэн төрлийн эрдэнэт биеэр ашдын амар амгаланд хүрч чаддагийг Бүдда, Богд Зонхава, Иволгын дацны хамба гээд олон хүн биеэр үлгэрлэн үзүүлсэн бөгөөд тэрхүү гэгээрэх үйлд хэлний зөв үйл чухал үүрэгтэй. Бүддагийн гүн ухаанд 10 нүгэл (биеийн 3 : - амь таслах, эс өгснийг авах, буруу хүсэлд автах; сэтгэлийн 3 : - хорлох, шунах, буруу үзэлд автах; хэлний 4 : - худал хэлэх, хов зөөх, ширүүн үг хэлэх, дэмий чалчих) - ийн дотор хамгийн олон нь хэлээр үйлдэх нүгэл гэж заасан буй нь энэ үйл хүний оршихуйд ямар чухал болохыг харуулж байна.

Ертөнцийн хүн, хүн бусын бүх үйл орчин(орон зай), цаг хугацаа, үйлийн барилдлага(шалтгаан, үр дагавар) – д тулгуурладаг учраас харилцах үйлийг гадаад, дотоод орчин, хам, цуваа цаг, эерэг сөрөг барилдлагаас ангид авч үзэх боломжгүй юм. Үүнд, бичил, бичил бус сав ертөнцийн хэсэг дэхь хүний(шим) ертөнцийн хүрээ харилцах үйлийн гадаад орчин; сэтгэлийн ертөнц дотоод орчин; гурван цагийн тасархай харилцах үйлийн цаг; бодит, бодит бус бүх юмын хөгжил хөдөлгөөн харилцах үйлийн барилдлага болно.

Аливаа харилцах үйл эерэг, сөрөг үнэлэмжид тулгуурласан догдлонгуй аяс илрэх дээд, доод; эерэг, сөрөг үнэлэмжид эс тулгуурласан догдлонгуй бус аяс илрэх дунд гэсэн гурван зэрэгтэй бөгөөд үүтгэх, үүтгэгдэх хоёр талыг түшиж бүтнэ. Ингэхдээ өгүүлэгдэхүүн, өгүүлэгч, өгүүлэхүйгээс бүрдэж, илэрхийлэх, хүртэх, сэтгэх, өчих үйлдлээр шүтэлцэн барилдаж хэрэгжинэ. Үүнд,

Харилцах үйлийн дээд, доод зэрэгт эерэг, сөрөг утгатай тусгай үг, хэллэг хэрэглэх ба ингэснээр догдлонгуй буюу хүндэтгэсэн, эс хүндэтгэсэн өнгө аяс заавал илэрдэг. Харилцах үйлийн өнгө аяс үнэлэмжид тулгуурлан үүсэх ба баймж (Юмыг шууд бус өгүүлэхийн хамтаар өгүүлэгчийн сэтгэлд нийцтэй, нийцгүй буйн санааг ямагт илтгэж байдаг нэгж) - тай шууд холбоотой байна.

Дээд зэрэг нь “ . . . субъектээс аль нэг хэрэгцээгээ хангах үүднээс тухайн объектийг хүсэх . . .” (Дорждагва. 2005. х- 40)³ буюу эерэг утга бүхий үнэлэмжээс үүдсэн бахдан бишрэх сэтгэлийн илрэл бөгөөд монгол хэл, сэтгэлгээний хөгжлийн явцад,

² Б.Ринчен (1991), Хэлээ хайрлан энхрийлж, үгийн боловсролыг эрхэмлэе, “Марк Твений минь махыг нь идэж дээ . . .”, УБ. 77-78 дугаар тал.

³ Т.Дорждагва (2002), Соёлын философи (түүхэн товчоон), УБ.

“Улс төрөө хүндлэхийн учир
Удирдах тэргүүлэх даргыг хүндэтгэнэ
Ухаан эрдмийг хүндлэхийн учир
Ухуулах сургах багшийг хүндэтгэнэ”

гэх мэтээр аав ээж, ах захаа хүндлэн харилцах, хүн бүрийг Та гэж хүндэтгэн харилцах, албан тушаал, ажил мэргэжлийнх нь онцлогт тохируулан хүнийг хүндэтгэн харилцах, бас лам багш, бурхан шүтээн, уул нуруу, гол мөрнийг хүндэтгэн нэрлэх үндэстний сэтгэлгээний тогтсон журам, соёлч боловсон харилцааны арга хэвшил болон тогтжээ.

Доод зэрэг нь “... сүбъектээс тухайн объектийг үл хүсэх” (Дорждагва. 2005. х-40)⁴ буюу сөрөг утга бүхий үнэлгээний илрэл бөгөөд утгын хувьд дээд зэрэгтэй эсрэгцсэн, “Тэрэгчийн үйсэн овоохойд гэрийн буг болж, модны мөөгөөр шөл ууж байвал таарах нови...” (Ш.Гаадамба. Тэрэгчийн хүү) гэх мэт доромж өнгө аястай байдаг.

Дунд зэрэг нь догдлонгуй бус бөгөөд өгүүлэгдэхүүн(утга санаа) - ийг ерийн байдлаар дамжуулах үүрэгтэй, “Отгонтэнгэр уул... Хангайн уулархаг мужийн мөнх цаст 4031 м өндөр оргил”(МНТ. 2000. х – 682 – 683)⁵ гэх мэт энгийн өнгө аястай байдаг. Гэтэл, “Оройн чимэг болсон Отгонхайрхан уул аа... Очир мутарласан шүтээн шиг Очирваань хайрханаа биширнэ ээ”(Очирваанийн дуулал оройн чимэг.УБ.2011) гэсэн шүлгийн хэсэгт болсон, уул хоёроос бусад нь цөм дээд зэрэг илтгэх догдлонгуй аястай үг байна.

Өнгө аяс гэж харилцах үйлийн зэргээс шалтгаалан илэрч буй нэмэлт утгыг хэлнэ.

Үүтгэх тал нь харилцах үйл эхлүүлэн гүйцэтгэх шаардлага тулгарсан эзэн.

Үүтгэгдэх тал нь харилцах үйлд татагдан оролцох хэрэгтэй болсон эзэн.

Өгүүлэгдэхүүн нь үндэстний сэтгэлгээний утга (ертөнцийн юм, үзэгдлийн дүр зураг) - ыг тархиндаа буулган авч ухамсарлан нэрлэсний үр дүн болох харьцангуй үнэнийг харилцааны тухайн орчинд илэрхийлэн танилцуулахаар, гадаад дотоод харилцааг нь хэлний нэгжээр илтгэсэн үндэстний сэтгэлгээний тэмдэг, хийсвэр ухагдахуун буюу харилцах үйлийн мөн чанар.

Өгүүлэгч нь өгүүлэгдэхүүнийг бичих, ярих зэргээр илэрхийлэн танилцуулах эзэн буюу харилцах үйлийг үүтгэгч.

Өгүүлэхүй нь тухайн орчинд өгүүлэгчээс өгүүлэгдэхүүнийг илэрхийлэн танилцуулахаар бэлтгэж буй гадаад, дотоод харилцах үйл бөгөөд үүнийг тоочих(тоочимж), тайлбарлах (тайлбарламж) эргэцүүлэх(эргэцүүлэмж), хүүрнэх (хүүрнэмж) өгүүлэхүй гэж ангилдаг. Үүнд,

"Борзонгийн говь, Нарийн хөхийн говь, Элгэн усны говь, Хонин усны говь, Цэнхэр номины говь, Галбын говь, Хүйсийн говь, Шанхын говь, Шаргын говь гэж ярилцдаг" гэх мэтээр юм, үзэгдлийн гадаад, дотоод шинжийг зүйлчлэн ангилж дурдан, ерөнхий дүр төрхийг зураглаж, зогсонги шинжийг тодорхойлох орон зайн холбоотойгоор, шууд нэрлэн өгүүлэхийг тоочин өгүүлэхүй ;

"Хоёр талын ханан өндөр чулуун байцад говийн агь өвсний хөх бут ов тов харагдана. Шим тэжээлээр дутмаг чулуун байцын үе судлыг дагаж тогтсон өчүүхэн хэсэг хөрсөнд ургасан агь өвсний бут хавцлыг уруудан үлээх хүчтэй салхинд

⁴ Т.Дорждагва (2002), Соёлын философи (түүхэн товчоон), УБ.

⁵ Монголын нэвтэрхий толь. II (2000), УБ.

тогтоож ядан сөрвөлзөнө. Говийн нарны халуун илчинд шарагдаж гилгэр хар өнгөтэй болсон жижиг хайрга чулуугаар бүрхэгдсэн элсэрхэг зөөлөн хөрснөөс улаан тоос бужигнан дэгдэж, удтал замхрахгүй, утаа униар мэт зурайн хоцорно" гэх мэтээр юм, үзэгдлийн хувирал өөрчлөл, хөгжил хөдөлгөөний мөн чанарыг тодруулан, шинэ санаагаар баяжуулж, дүгнэж цэгнэн илэрхийлдэг, учир шалтгааны холбооноос үүдэлтэй төсөөлөлд тулгуурласан ухаарлын шинжтэйгээр, шууд бус нэрлэн өгүүлэхийг тайлбарлан өгүүлэхүй ;

"Говь буюу цөлөрхөг хээрийн бүс гэж нэрлэдэг энэ бүс хээрийн бүсийг бодвол хур тундас бүр багатай учраас уур амьсгал нь илүү хуурай юм. Говийн бүсэд бор хөрс бүрэлдэн тогтоож, бүсийн ихэнх нутгийг бүрхжээ. Говийн ургамал тачир бөгөөд газрын хөрсийг нийтэд нь бүрхэж чадахгүй, энд тэнд ургана" гэх мэтээр юм, үзэгдлийн дотоод зүйтогтлыг батлах, үгүйсгэх зэргээр тодруулан дүгнэж илэрхийлдэг, ухагдахууны хоорондын харилцаанд тулгуурласан бодомж, оюун дүгнэлт байдлаар шууд нэрлэн өгүүлэхийг эргэцүүлэн өгүүлэхүй ;

" Шархтай гөрөөс нь

Элсээ цусдахгүй гэж

Цусаа долоож эдгэдэг говь

Сайхан бүсгүйчүүд нь

Эрээ гутаахгүй гэж

Бүсээ чанга бүсэлдэг говь

Нар ёроолд нь харваж хүрдэггүй

Худгийн ус нь

Ховоо дагжим хүйтэн

Сар тээглэж хонодог цохио

Газрын хадан эвэр

Уулсын орой нь халуун

Халуун хүйтэн хоёр

Орчилдож

Тогтсон хязгаар

Хатуу нь зөөлөндөө

Дийлдэж

Бүрэлдсэн нутаг . . .

Айлын сувдан бараа

Малын үнэр нь

Амин хайр

Аргамжаатай ботго нь

Тэр чигээрээ

Морин хуур . . ." (Б. Лхагвасүрэн. Говь. "Хос уянга. УБ. 1991". х - 11 - 13) гэх

мэтээр юм, үзэгдлийн хувирал өөрчлөл, хөгжил хөдөлгөөнийг оронзай дахь дарааллаар нь дүрслэн өгүүлдэг, хэрэг явдлын хөдлөнги шинжийг тодорхойлох тул цаг хугацааны холбогдолтой байдаг, шууд бус нэрлэсэн шинжтэй өгүүлэхүйг хүүрнэн өгүүлэхүй гэх ба хэлний төгс, төгс бус нэгжээр сав, шим ертөнцийн юм, үзэгдлийн талаархи ухагдахууныг сэтгэлгээний ертөнцийн тэмдгийн тал дээр аливаа далд санаа, нуугдмал утгагүйгээр илэрхийлэн тэмдэглэхийг шууд нэрлэх; сэтгэлгээний ертөнцийн хувиргал, соёлын тал дээр, хэлзүйн хэлбэр, бүтэц, агуулга зэрэг аль нэг

талаар нь далд давхар санаа, шилжсэн нуугдмал утгатайгаар илэрхийлэн тэмдэглэхийг шууд бус нэрлэх гэнэ.

Өгүүлэхүй бүрт үүтгэх талаас үүтгэгдэх талд хийсвэр, хийсвэр бус юмыг мэдээлэх, нөлөөлөх зорилгоор; өгүүлэхүйн зэрэг, төрлөөр; цагийн хэмжээс дотор болон оронзайд; аман, аман бус хэлбэрээр; албаны, албаны бусаар илэрхийлэх гэх зэрэг харилцан нөхцөлдсөн агуулгын бүрэлдүүлбэр байдаг. Энэ агуулгын бүрэлдүүлбэрийг хэн, хэнд, юуг, яах гэж, өгүүлэхүйн аль зэргээр, ямар төрөл зүйлээр, юугаар, хэзээ, хаана, ямар өнгө аясаар, хэрхэн өгүүлэх хэмээн товчоолж болохыгдээр хэсгийг нь эшилсэн "Говь" шүлгээр жишээлэн үзүүлбэл,

- Хэн : Үүтгэн өгүүлэгч Б.Лхагвасүрэн
- Хэнд : Үүтгэгдэх талд
- Юуг : Говийг
- Яах гэж : Мэдээлэн нөлөөлөх гэж
- Өгүүлэхүйн аль зэргээр : Дунд зэргээр
- Ямар төрөл зүйлээр : Уран сайхны эх, уянгын зохиолоор
- Хэзээ : Байнгын язгуур бус цагийн хэмжээс дотор
- Хаана : Язгуур бус оронзайд
- Ямар байдлаар : Магтан бахархах өнгө аясаар
- Юугаар : Монгол хэлний дотоод, гадаад сангийн их, бага нэгжээр
- Яаж : Аман бус хэлбэрээр, шүлэглэж гэх мэт.

Илэрхийлэх нь өгүүлэгчээс өгүүлэхүйг гарган танилцуулах гадаад харилцах үйл.

Хүртэх нь өгүүлэгчийн илэрхийлэн танилцуулж өгүүлснийг харилцах үйл үүтгэгдэх тал сонсон(уншин) хүлээж авах үйл явц.

Сэтгэх нь харилцах үйл үүтгэгдэх тал хүртэн хүлээж авснаа шинжлэн дүгнэх дотоод харилцах үйл.

Өчих нь үүтгэгдэх тал шинжлэн дүгнэж боловсруулсан өгүүлэгдэхүүнийг гарган танилцуулах гадаад харилцах үйл.

Харилцах үйлийн бүтцийн нэгжээс онцлон үзвэл зохилтой нь үндэстний сэтгэлгээний утга, тэмдгийг хувирган хэрэглэж, харилцах үйл үүтгэн бүтээх гол эзэн буюу өгүүлэгч (үүтгэгч) юм. Тухай тухайн харилцааны орчинд илэрхийлэн танилцуулж буй санааны соёл (өгүүлэхүй) ямар болох нь өгүүлэгчийн мэдлэг боловсрол, дадлага туршлага, зан төлөв, төрөлхийн авьяас билиг, ялангуяа, уламжлалт Монгол гүн ухаанд, “Сэтгэл гэгч түмэн хэргийн үндэс, сайн муугийн гарах орон болой. Сэтгэлд үгүй бол нүд үзэвч өнгийг үл ялгана. Сэтгэлд үгүй бол идэвч амтыг үл ялгана. Сэтгэлд үгүй бол чихээр сонсовч утгыг үл ухна. Сэтгэл явдал буруудвал цог заль буурна” гэх мэтээр сургадаг, сэтгэлээс шалтгаална.

Өгүүлэгчийг сэтгэлийн эрдэм, иргэний боловсрол, сэтгэхүйн төгөлдөршил, тэдгээрт тулгуурласан номлох чадвараар нь гэгээрсэн ба гэгээрч яваа өгүүлэгч гэж ялгаад, сүүлчийнхийг гэгээрч яваа дээд өгүүлэгч, гэгээрч яваа дэд өгүүлэгч хэмээн ангилж болно. Үүнд,

1.Гэгээрсэн өгүүлэгч. Ийм өгүүлэгчийн тоонд Шагжамүни(Бүдда), Гомболүдүв (Наганжүна буюу монголчууд Нагаржүна гэдэг), Бадмасамбава, Зонхова, Далай лам зэрэг хоосон чанар, мөнх бус, үйлийн үрийг онож, орчлонгийн мөн чанарыг танин, билгийн чанад хязгаарт хүрч төгс гэгээрсэн саруул ухаантан - энэрэн нигүүлсэх сэтгэлтэн - утга төгс уран яруу номлолтон - мөнхийн сургаалтан - төгс гэгээрэлд

хөтлөгч - сэтгэлийн аугаа их залуурч нар багтах бөгөөд өгүүлэгдэхүүн нь арван зүгийн гурван цагийн бүх далд, далд бус ертөнцийн гадаад, дотоод орны цөм, цөм бус бүх утгыг бүгдэд номлосон туйлын үнэн, өгүүлэхүй нь яруу сонсголон, сэтгэл татах увидас байдаг. Ташрамд дурдахад, монгол хүн Бурханы хэмээн нэрлэж заншсан шашин бол Бүддагийн шашин бөгөөд Бүдда нь эртний санскрит хэлээр ухаарч гэгээрсэн гэсэн утгатай үг юм. Дэлхий дээр нийт мянган Бүдда Бурхан залран ирж ном сургаал айлдан, зургаан зүйлийн хамаг амьтныг гэгээрүүлж, зовлонгоос гэтэлгэх тангарагтайгаас зөвхөн дөрөв нь ирсний дөрөвдөх нь Шагжамүни бөгөөд түүнийг ЗТӨ 623 оны зуны эхэн сарын 15-нд мэндэлсэн (Дулам, 2004. х-50)⁶ гэж үздэг ч В.Инжиннаш түүний мэндэлсэн онлолыг ЗТӨ 1020 оны 4 сарын 8 буюу зуны эхэн сарын 8 гэж үздэг байжээ. Ямар боловч, Бүдда бол “... оюун ухаан далай тэнгис лүгээ адил зах хязгааргүй, сэтгэл нь асар нигүүлсэнгүй, энэрэхийн дээд биелэл бүлгээ... тэрээр биеэ зөв авч явах чадвар, суут үзэл бодол, суут оюун ухаан, суут номлох чадвар, хүнийг зөв замд оруулах суут чадвар...” гэсэн таван бодь чанартай; “... тэрээр хүнд аз жаргал, сайн сайхныг авчирдаг; тэрээр нүгэл буян, үнэн худлыг зөв сургадаг; түүний сургаал ертөнцийн тусыг бүтээдэг; тэрээр зөв зам мөрийг заан сургаад, гэгээрэлд залан аваачдаг; тэрээр бүхнийг нэг л замаар дагуулан явдаг; тэрээр биеэ тоох, онгирч сагсуурахыг үл мэднэ; тэрээр хэлсэндээ хүрдэг, хэлсэн үгэндээ эзэн болдог; тэрээр өргөсөн тангараг, хүртсэн сахилаа чанд баримталдаг...” бөгөөд “... сургаалаа нэг хэлээр номлох атал хүн бүр өөрийнхөөрөө ойлгож, өөрт нь хандаж байна хэмээн боддог... төөрөлдөгсөд түүний сэтгэл санааг үл ойлгоно...” (Сургаал.1996. х-33-36)⁷.

2. Гэгээрч яваа дээд өгүүлэгч. Ийм өгүүлэгчийн тоонд Бүддагийн гүн ухаан болон бусад гүн ухааныг судлан дагагч, сурган номлогч нар; бүх шинжлэх ухааны мэргэжлийн багш, судлаач нар; бүтээн туурвих чадал, билиг авъяастан, аугаа их зохиолч, бичгийн мэргэд болон захиран жолоодох сэтгэлтэн, төрийг засах аргатан, ятган сэнхрүүлэх чадвар, бэлэн цэцэн үг яриатай, гүйлгүү ухаантай нийгэм – төрийн их хувьсган өөрчлөгч, удирдан дагуулах увдистан, тухайлбал, Хүн Гүрэний сайн эзэн буюу эртний хятад түүхчийн сонсон тэмдэглэснээр Маодун(Маадар буюу Баатар гэсэн утгатай), Чингис хаан, Күнз, Наполеон, Линькольн, К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин, Д.Бодоо, С.Данзан, Ж. Цэвээн, Д. Сүхбаатар, А.Амар, Мартин Лютер Кинг гэх мэт орчлонгийн мөн чанарыг таньж эхэлсэн олон хүнийг хамруулан дурдаж болох бөгөөд өгүүлэгдэхүүн нь ихэнхдээ гүн ухааны нэгэн урсгал чиглэл, нэгэн үзэл суртлын хүрээнээс үл давахуйц буюу хэдэн зуун, сайндаа л хэдэн мянганаас үл хэтрэх цөөн жилийн настай ч харьцангуй үнэнээс туйлын үнэн рүү алхам алхмаар дөхсөн шинжтэй байдаг.

3. Гэгээрч яваа дэд өгүүлэгч. Ийм өгүүлэгчийн тоонд дээр дурдсанаас бусад бүх өгүүлэгч багтах бөгөөд өгүүлэгдэхүүн нь харилцах үйлийн гадаад, дотоод орчин – цаг - барилдлагаар нөхцөлдсөн, тухай тухайн өгүүлэгчийн оюун санааны болон бодит аж амьдралын хэрэгцээ, шаардлагаас үүдсэн тодорхой учир шалтгаан бүхий, харьцангуйн доторхи харьцангуй үнэн байдаг.

⁶ С.Дулам (2004), Дорно дахины уран зохиолын үүд. УБ.

⁷ Бурхан Багшийн сургаал (1996). Токио.

Сав, шим ертөнцийн бүх юм, үзэгдэл, түүний дотроос хүний явдал суудал, ярих хэлэх цөм утга агуулга, нөхцөл шалтгаан, уялдаа холбоо, зорилго чиглэлтэй байдаг тул төгс гэгээрэлд хүрэх их аян замын өчүүхэн тасархай болсон энэ яваа насандаа хүн, нягтлан тунгааж зөвийг онох саруул сэргэлэн ухаанаар аливаад ямагт сэрэмжтэй хандаж, сэтгэлийн эрдэмд цаг наргүй шамдан, үг хэл, үйл хэргээ үргэлж хичээн боловсруулж явах нь нэн чухал бөгөөд ерөөс хүн бол “... түүхийн үйл явц, Дэлхийн эдийн болон оюуны соёлын хөгжлийн онохуй, амьдралын бусад хэлбэртэй удмын холбоогоор холбогдсон бөгөөд хөдөлмөрийн багаж зэвсэг хийх чадварынхаа ачаар тэдгээр хэлбэрээс ялгаран гарсан, авиа ялгаатай хэл яриа, сэтгэхүй, ухамсар бүхий байгаль – нийгмийн амьтан . . . хүний мөн чанар бол нийгмийн бүх харилцааны цогц мөн” (ФТ.1990. х-497)⁸ учраас нийгмийн гадна байх боломжгүй. Зөвхөн нийгэм дотор аж төрж, бусадтай байнга ярьж харилцаж, хамтран ажиллаж, бүтээж туурвиж яваа цагтаа л хүн жинхэнэ хүн байж чадна. Товчхондоо бол, жинхэнэ харилцах үйлгүйгээр хүн нийгмийн гишүүн байж чадахгүй, сэтгэлийн эрдэм, үндэстний сэтгэлгээний соёл боловсрол, сэтгэхүйн төгөлдөршилгүйгээр жинхэнэ харилцах үйл бүтэхгүй. Тийм учраас нийгмийн гишүүн хүн бүхэн,

1. Сэтгэл ариусахуйн эрдэмд ямагт боловсрон гэгээрэх хэрэгтэй. Үүнд,

“Сэтгэлийн туйлын мөн чанар нь тунгалаг гэрэл мөн. Сэтгэл олон төвшинтэй бөгөөд эгэл төвшин нь муу хүчинд өртсөн байдаг. Сэтгэлийн хамгийн нарийн төвшин бузартаагүй ариун байдаг . . . Сэтгэлийн нарийн төвшинг тунгалаг гэрлийн сэтгэл гэдэг . . . Сэтгэлийн эгэл төвшинтэй нөхцөдөг юм бол эндүүрэл, орчлонгийн хүлээс(нисваанис), эргэлзэхүй(үл итгэхүй буюу хоёрдмол сэтгэл), энэрэл, хорсол . . . Эндүүрэл сэтгэлд давамгайлахад сүүтгэр үйл дагалдаж, үүгээр орчлонгийн (сансрын) хорт цагираг биднийг урсгалдаа оруулснаар удалгүй бид биеэ хянан барих чадваргүй болно. Амьдрал биднийг харанхуй руу хөтөлж, үхэл нүцэглэж, хоосон мөрөөдөлтэй үлдээнэ. . . Эндүүрэл, бодитоор оршоогүй юмыг бодитой гэж гүн итгэсэн итгэл дээр үндэслэсэн тул билиг оюун, сүсгийн бусад чанар эндүүрлийг хурдан арилгана . . . Зовлонгоос ангижрахын тулд хүн хувийн сахилга(шагшаавад), бясалгал(самади), хоосон чанарын билиг гэсэн гурван суртлыг төгсгөх ёстой . . . Эдгээрийн дотроос хамгийн чухал нь хоосон чанарын билиг юм. Сүсэглэх, бясалгах ажлыг сэтгэлийн эгэл төвшин дотор эхэлж, амьдралын мөн чанарыг тунгаах ёстой . . . Хорслын оронд энэрлийг, уурлахын оронд хүлцэхийг, шуналын оронд чөлөө учрал (1. Тамд эс төрсөн, 2. Бирдэд эс төрсөн, 3. Адгуусанд эс төрсөн, 4. Тэрсүүдэд эс төрсөн, 5. Урт наст тэнгэрт эс төрсөн, 6. Буруу үзлээс ангид төрсөн, 7. Бурхан залраагүй оронд эс төрсөн, 8. Эрхтэн гүйцэт бусаас зайлан төрсөн найман чөлөө; 1. Хүн байхын, 2. Бурханы орноо төрөхийн, 3. Эрхтэн бүрэн байхын, 4. Үйлийн хязгаар үл буруудсаны, 5. Номд сүсэгтэй байхын, 6. Бурхан заларсан байхын, 7. Дээдийн номыг айлдсан байхын, 8. Шашин оршин байхын, 9. Түүнийг даган орохын, 10. Бусдын тусад насад энэрэхийн арван учрал)⁹ -ыг буюу сэтгэл ханахуйг, балмадын оронд ач тусыг гэх мэтээр санах ёстой. Ингэвэл сэтгэл уужирч, амгалан болно . . . “Би” - гийн болон юм үзэгдлийн язгуурын мөн чанар хоосныг танивал үнэнхүү бодит хэмээхээс үүдсэн

⁸ Философийн толь (1990). УБ.

⁹ Бүддагийн шашин, соёлын тайлбар толь (2000). УБ. 1-84-85; 2-111-112

эндүүрлийн тоо томшгүй хэлбэр шууд алга болно. Хоосон чанарын билгийг төгс бөгөөд хүчтэй болгохын тулд юуны өмнө бясалгал(самади)-ыг хөгжүүлэх ёстой. Бясалгал(самади)-ыг тэтгэн хөхиүлж хөгжүүлэхийн тулд сэтгэлийг амарлиулж, бясалгалд нэмэрлэх уур амьсгалыг нөхцөлдүүлдэг хувийн сахилга(шагшаавад)-ын суртлыг үүсгэн хөгжүүлэх ёстой. Орчлон гэдэг сая сая жилийн амьдралын хэвшилтэй. Бидний амьдрал олон он жилээр орчлонгийн амьдралын замд идээшсэн учраас байнгын шаргуу, лавшруулах сэтгэл л амжилтанд хүрэх урьдчилсан нөхцөл болно . . .” (Тунгаамал алтан. УБ. 2003. х-32-35)¹⁰. “Ялсан этгээд үзэн ядах үзлийн үрийг суулгаж, ялагдсан нь зовлон шаналалд автана. Ялах, ялагдахын аль алинаас ангижирсан хүн амар амгалан, баяр баясгалангийн дээдийг эдэлнэ.

Өлсөх хамгийн шаналгаат өвчин, биеийг олох хамгийн шаналгаат зовлон. Энэ бүхнийг үнэн зөв ухаарвал нирваан цэнгэлийн дээд гэдгийг ойлгоно.

Намар цагт лянхуа цэцгийг тайрах лугаа адил хүслийнхээ үндсийг таслах нь зүйтэй. . . Сэтгэл санаагаа төгс төгөлдөр болгож, амар амгаланг ологтун.

Эрдэнэт хүний биеийг олж төрөх хэцүү. Үхэх цаг ирэхэд үхэхгүй байх хэцүү. Ариун үнэнийг олж сонсох хэцүү. Бурхан багшийг олж харах хэцүү.

Ариун ёст хүнийг олох хэцүү. Тийм буянтан газар сайгүй мэндлэх нь үгүй. Тийм ухаант хүн мэндэлсэн овог удам жаргал цэнгэлд умбаж, цэцэглэн мандана. (Сургаал.1996. Дармабада)¹¹.

Сэтгэлийн эрдмийг боловсруулан ариусахын тулд ямагт сэрэмжтэй байж,

“Үйлийн шалтгаан нь өөрийн сэтгэл мөн

Тэр сэтгэл ариудваас үүссэн үйл нь ариухан . . .

Хожмын алдаа хонжоог

Сэтгэлийн үндсэнд шинжил . . .

Хаана суувч сэтгэлээ аж

Хатуу үг, омгийг тэвч

Цагаан лянхуа мэт хир халдалгүй

Цасан өнгө мэт цагаан сэтгэлт бай” (МЗТББ.1968. х – 54; 60; 79 - 80)¹² хэмээсэн болон “ . . . зөв үзэл, зөв байдал, зөв үг, зөв үйл, зөв амьдрал, зөв тэмүүлэл, зөв дурсамж, зөв төвлөрөл . . .”(Сүхбаатар. 2006. х – 54)¹³ гэсэн найман зөв замыг насад алдалгүй дагаж, “Ослыг хичээнгүй дийлбэл сайн, хичээнгүйг осол дийлбэл сөнөнө. Хүслийг журам дийлбэл сайн болно. Журмыг хүсэл дийлбэл муу болно. Омгийг бадруулж болохгүй. Цэнгэлийг туйлд хүргэж болохгүй. Эдтэй учирвал олохыг бүү хичээ. Хилэнд дийлэхийг бүү хичээ. Хуваахад илүүг бүү эр. Үгэнд шударга бат, явдалд чин үнэн хичээнгүй бол”(Хүрэлбаатар. 2002. х-163-164)¹⁴ хэмээсэн эртний сургаалыг үргэлж санаж явах нь чухал юм.

2. Улсын иргэний боловсрол буюу үндэстний сэтгэлгээний утга, тэмдэг, хэрэглээ, соёлд үргэлж хичээн суралцах хэрэгтэй. Үүнд,

¹⁰ Гуравдугаар Далай Лам (2003), Тунгаамал алтан, УБ.

¹¹ Бурхан Багшийн сургаал (1996), Токио.

¹² Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл (1968). 2-р дэвтэр. УБ.

¹³ Ц.Сүхбаатар (2006), Найруулгазүйн судалбар, УБ.

¹⁴ Л.Хүрэлбаатар (2002), Судар шастирын билиг, УБ.

Оршихуйд шууд нөлөөлөх үнэлэмжийг амин үнэлэмж, шууд эс нөлөөлөх үнэлэмжийг амин бус үнэлэмж гэх бөгөөд эд баялаг, зугаа цэнгэл, алдар нэр, ашиг завшаан гэх мэт зүйл зүйлийн амин бус үнэлэмжээс сэтгэлээ чөлөөлөн, Монголын иргэний боловсролын удиртгал буюу оршихуйн үндэс болсон,

А. Амь бие аюулгүй амгалан оршихын үндэс – Эх нутаг, газар шороо, түүнийг эрхэмлэн дээдлэх

Б. Амин тэжээл элбэг хангалуун оршихын үндэс – Мал сүрэг, түүнийг эрхэмлэн дээдлэх

В. Эрдэм ухаан тэгш дүүрэн оршихуйн үндэс – Эх хэл, үндэсний монгол бичиг, түүнийг эрхэмлэн дээдлэх

Г. Сэтгэл санаа амгалан ариун оршихуйн үндэс – Бурханы шашин, түүнийг эрхэмлэн дээдлэх

Д. Хүч чадал төгс бадрангуй оршихуйн үндэс – Эв нэгдэл, түүнийг эрхэмлэн дээдлэх

Е. Эх орон ашид мөнх мандан бадрахын үндэс – Төр, засаг, түүнийг эрхэмлэн дээдлэх зэрэг амин үнэлэмжид тургуурлан, Монголын улстөрийн түүх, гүн ухаан – зан сэтгэлгийн түүх, шашин суртахууны түүх, эдийн засгийн түүх, газар нутгийн түүх, сэтгэлгээний түүхийг нарийвчлан судалж, монгол аж төрөх ёсноос тасралтгүй суралцан, хэвээ сахисан аж амьдрал(гэр орон, амин зуулгын хөрөнгө, хөрөнгөө сэлбэх арга, сэтгэлд зохист хань ижил) -тай жинхэнэ эх оронч иргэн болж төлөвшөөд, “Биеэ засаж, биеэ засаад гэрээ засаж, гэрээ засаад Төрөө засаж”(Монгол оршихуйн гүн ухааны сургаалаас), Монгол түмний оршихуйн бүх үндсийг хайрлан энхрийлж, хамгаалан бататгахын төлөө мөнхөд тэмцэх ёстой бөгөөд хүн бүрийн, түүний дотроос, Монгол Улсын иргэн бүрийн бодож сэтгэх, хэлж ярих, хийж гүйцэтгэх бүх ажил үйлийн дотор Эх орны хувь заяа, ард түмний оршихуйтай холбоогүй юм нэг ч байхгүйг хэзээ ч үл умартан, үндэстний оршихуйн эсрэг чиглэсэн буруу үзэл санаа, аюул учруулж болох аливаа хорт түрэмгийлэл бүрийг ямагт соргоогоор мэдрэн шинжилж, жинхэнэ утга, мөн чанарыг нь уудлан таньж, улс үндэстнээ өнө үүрд мандуулан бадраах үйлсэд ухамсарт амьдралаа бүрэн зориулж, “Хэл, хил, мал гурвынхаа төлөө Энэ яваа насаа эцэслэн дуустал . . .” тэмцэж, “Хэл, хил, мал гурвынхаа төлөө Үхсэний дараа сүнс гэж байдаг бол Үргэлжлүүлж бас . . .” тэмцэх хэрэгтэй(Зундуйн Дорж.Миний тунхаглал."Хасагдавч үрэгдээгүй зохиол, хаягдавч дарагдаагүй тохиол. УБ.2011. х - 7). Товчхондоо бол,

“Эрдэнэт хүний биеийг олоод

Этгээд буруу хэргээс зайлуулж

Эдүгээ ирээдүйн хоёр үйлсийг бүтээхүй . . .

Сайн үйлсийн тулд

Амин зүрхнээсээ

Сайхан Төрийн тулд

Ахуй чинээгээрээ

Сайтар шамдан зүтгэлтэй . . .” “Түмэн эх” (Монгол дууны дээж). УБ. 1986. х - 3) бөгөөд энэ бүхний амин сүнс, гол зориулга нь өөрийн Эх орон, ард түмэн, ерөөс хүн төрөлхтний өнө мөнхөд оршихуйн өмнө хүлээх асар их хариуцлага, эрдэнэт хүний эрхэм дээд төрлийг хайрлан сахиж, төгөлдөршүүлэх ариун үүрэг мөнийг гүнзгий ухамсарлах ёстой.

3. Хүний хөгжил буюу бие, сэтгэхүйн төгөлдөршилд байнга шамдах хэрэгтэй.

Үүнд,

Эрүүл биед саруул ухаан оршдог учраас эрүүл чийрэг бие бялдартай байх хэрэгтэйн дээр учрахуйяа бэрх атлаа алдагдах нь хялбар эрдэнэт хүний биеийг олон төрсөн бахархлаар ёс журам, тэр тусмаа, Монгол ёс журмыг чанд сахиж, өөрийн болон Монгол хүний, цаашилбал, эрдэнэт хүний нэр төрийг өндөрт өргөж явдаг, энэрэн нигүүлсэх, туслан дэмжих өр нимгэн сэтгэл, чин шударга, цэвэр ариун, эрхэм дээд ёс суртахуунтай, “Номд мэргэн, нойрт сэргэг, дайнд баатар, далайд усч, үйлэнд уран, үгэнд цэцэн, дээдэд хүндлэлтэй, доордод асралтай, хувийн ашиг сонирхлыг нийтийнхээс дээгүүр тавьдаггүй, Төрлөө түшигтэй, түмэн олондоо ачтай элбэрэлтэй”(Монгол ардын билиг сургаалаас), аливаад мухар сүсгээс ангид, шинжлэх ухаанчаар ханддаг, бүтээлч, өөдрөг сэтгэлтэй, тал бүрийн боловсролтой, үвтэгш(хувь тэгш, арван хуруу тэгш, эрхэм сайн) хүмүүжилтэй буюу саруул ухаанаар жигүүр хийж, сайн үйлд цаг наргүй шамддаг болох нь чухал.

Хураангуйлан хэлэхэд, харилцах үйлийн ердийн зорилго бол мэдээ солилцох, ойлголцох, бие биедээ нөлөөлөх замаар өөр, бусдын оршихуйг нөхцөлдүүлэн амилуулж тохинуулан тогтоох явдал байдаг бол Бүддагийн шашны соёлын хүрээний хувьд бол харилцах үйлийн туйлын зорилго хүнийг орчлонгийн хүлээснээс алдууруулах явдал буюу мунхаг харанхуйн зовлонгоос гэтэлгэж, төгс гэгээрэл, мөнхийн амгаланд хүргэх явдал юм.

Өгүүлэгч санаагаа үг, хэллэг, биеийн хөдөлгөөнөөр дамжуулан илэрхийлэх ба хүлээн авагч түүнийг нь тэр даруй хүртэн хүлээж аваад, дотоод харилцахуйдаа нэн хурдан шинжлэн ойлгож, үнэлж дүгнэн, шаардлагатай бол гадаад харилцахуй бүтээнэ.

Харилцах үйлийн гадаад цөм утга маш олон зүйл боловч түүнийг захиран даалгахуйн, мэдээлэн таниулахуйн, ухуулан сэнхрүүлэхүйн харилцах үйл хэмээн бүлэглэж болох бөгөөд эдгээр нь үүтгэгдэх талд зөвхөн хэлээр дангаар өгүүлэх гадаад харилцахуй болж очдог. Үүнд,

Нэг. Захиран даалгахуйн харилцах үйл бол зөвхөн хэлээр дангаар өгүүлэх гадаад харилцахуй бөгөөд аман, аман бус хувилбар байж болно.

Захиран даалгахуйн харилцах үйл үндэстний сэтгэлгээний соёлын хувьд бол Улсын албаны бичиг баримтын эхийн өгүүлэхүй, тэр тусмаа, зарлиг, захирамж, тушаал, шийдвэр, тогтоол, албан даалгавар, албан шаардлага зэрэг **захирамжлах бичиг баримтын эхийн өгүүлэхүйгээс** бүрддэг. Үүнд, байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд удирдлагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор баталж гаргасан, чанд дагаж мөрдөх, заавал биелүүлэх шинж бүхий бичиг баримтыг захирамжлах бичиг баримт, орон даяар харилцааны хэрэглүүр болж байгаа бичиг баримт бүрийн хэлийг бичиг баримтын эхийн өгүүлэхүй гэдэг бөгөөд энэ өгүүлэхүй доорхи онцлогтой. Үүнд,

- Эхэд тоочих өгүүлэгдэхүүн голлож, бусад нь зохисоор дагалддаг.
- Эхийн өгүүлэмж утгын дараалал, шалтгаанч холбоо хамаарал сайтай байдаг.
- Эхийн өгүүлэмжийн доторхи хэсэг өөр зуураа зөрчилдсөн шинжгүй байдаг.
- Эхийн доторхи утга төгс санаа илэрхийлэх нэгжийг бүх бүтцээр нь урьдчилан тунгаан нягталж сонгодог.

Хоёр. Мэдээлэн таниулахуйн харилцах үйл аман, аман бус хувилбараар илэрч болох бөгөөд энэ хэсэгт,

- Нэг сэдэвт зохиол, судалгааны өгүүлэл буюу эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, ангийн ажил, дипломын зохиол, зэрэг хамгаалах зохиол, хураангуй, товчлол, шүүмж, үнэлгээ, танилцуулга, зарласан сэдэв, зохиогчийн гэрчилгээ, товч мэдээ, хялбаршуулсан зохиол, лекц, эмхтгэл, толь бичиг, лавлах, номзүйн жагсаалт, нэрийн хэлхээ, зүүлт, сурахбичиг, заах аргазүйн ном зохиол, тэмдэглэл, тайлбар зэрэг улс нийгмийн өдөр тутмын амьдралыг шинжилгээ судалгааны бүх салбарын хүрээнд зохицуулах хэрэглүүр болж байгаа Улсын хэлний аман, аман бус хэлбэр болох **шинжлэх ухааны эхийн** өгүүлэхүй;

- Судалгааны зохиолын эхийн өгүүлэхүй, туулийн зохиолын эхийн өгүүлэхүй, жүжгийн зохиолын эхийн өгүүлэхүй, уянгын зохиолын эхийн өгүүлэхүй, өмнөх үгийн, төгсгөлийн үгийн, хянан тохиолдуулагчийн үгийн, өгүүллийн өгүүлэхүй зэрэг үндэстний хэл, сэтгэлгээний утга, тэмдгийн баялаг хэрэглүүр, санаа илэрхийлэх бүх боломжинд тулгуурлан бүтдэг **урансайхны эхийн** өгүүлэхүй;

- Мэдээ, сурвалжлага, сурвалжилсан яриа, тайлан мэдээ, тайлан, ярилцлага, шуурхай ярилцлага, асуулт, байцаал(асуулга), биеийн байцаал, санал асуулга, тайлбар, үзлэг(хяналт), голч тойм, тойм, уучлал, зөвлөгөө, эмгэнэлийн мэдээ, захидал, сэтгэгдэл, дурсамж, өгүүлэл, эсээ, шүүмж, тэмдэглэл, сурвалжилсан тэмдэглэл, тэмдэглэсэн сурвалжлага, шалгаруулал, эрэл хайгуул(эрэн сурвалжлахуй), баримжаалал, хувилбар, туршилт, найруулал, шог найруулал, хочлол, элэглэл, шог тайлбар, нийтлэл, харууслын үг зэрэг нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах зорилгоор сонин хэвлэлд нийтэлсэн; радио, телевизээр нэвтрүүлсэн зүйлийн (Сүхбаатар. 2004. х-347)¹⁵ өгүүлэхүй буюу урансайхны эхийн, бичиг баримтын эхийн, шинжлэх ухааны эхийн өгүүлэхүй зэрэг улс орон даяар өдөр тутам харилцааны хэрэглүүр болж байгаа эх хэлний өгүүлэхүйн бүхий л төрөл зүйлийг тодорхой хэмжээгээр агуулж, тус тусын онцлогийг илэрхийлж байдаг **нийтэлгээний эхийн** өгүүлэхүй;

- Мэдээ, санал, танилцуулга, тодорхойлолт, илтгэх хуудас, илтгэл, өргөдөл, ажил байдлын тодорхойлолт, баримт, захидлын найруулга зэрэг байгууллага, хамт олны ажил хэргийн явц байдал, албан тушаалтны үүргийн биелэл хэрэгжил, хувь хүний санал хүсэлт, зорилго эрмэлзэл зэргийг агуулсан, мэдээг шуурхай хүргэх үүрэгтэй, тодруулан тайлбарлаж таниулах шинж бүхий **мэдээ-лавлагааны бичиг баримтын** өгүүлэхүй;

- Акт, албан бичиг(албан тоот), зөвлөмж, гэрээ, дүгнэлт, дүрэм, журам, заавар, төсөл, тэмдэглэл, удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө, мэдэгдэл, тайлан, илгээлт(мэндчилгээ) зэрэг байгууллага, албан тушаалтнаас ажил албаны тодорхой зорилтыг хэрэгжүүлэх, бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулахтай холбоотойгоор үйлдэн хөтөлж буй, хэм хэмжээ тогтоох, журамлах, зохицуулах шинж бүхий **зохион байгуулах бичиг баримтын** өгүүлэхүй багтана.

Мэдээлэн таниулахуйн харилцах үйл чөлөөт, чөлөөт бус өгүүлэхүйн аль алины шинжийг агуулж байдаг бөгөөд түүнд багтдаг бичиг баримтын өгүүлэхүйн

¹⁵ Ц.Сүхбаатар (2004), Монгол хэлний найруулгазүй.

онцлогийг дээр дурдсан тул энд давтан нуршилгүй, зөвхөн үлдсэн гурван өгүүлэхүйн төрөл, зүйлийн онцлогийг товч тодруулбал,

1. Шинжлэх ухааны эхийн өгүүлэхүй доорхи онцлогтой. Үүнд,

- Эхийн өгүүлэмж Монгол хэлний өгүүлэхүйн дүрэм буюу Өгүүлэхүйн сэтгэлгээний дүрэм, Хүндэтгэл илэрхийлэх дүрэм, Үг хувилгах, холбох дүрэм, Үгийн сан, орчуулгын дүрэмд нийцсэн байна.

- Эхийн өгүүлэмж ерөнхийгөөс тодорхой руу, тодорхойгоос ерөнхий рүү чиглэсэн утгын дараалал сайтай байна.

- Эхийн өгүүлэмж таамаг, баримтанд тулгуурласан эргэцүүлэмж, тайлбарламж, нотолгоо, дүгнэлт гэсэн дарааллаар бүтнэ.

- Эхийн өгүүлэмж үгийнсан – утгазүйн холбоо хамаарал сайтай тодорхой үгс болон ганц утгат өгүүлбэр, нэр томъёогоор илэрнэ.

- Эхийн өгүүлэмж доторхи утга төгс санааг урьдчилан бодож тунгаасан нэгжээр илэрхийлнэ.

- Эхийн өгүүлэмж бүхэлдээ дангаар өгүүлэх гадаад харилцахуй байдаг.

2. Нийтэлгээний эхийн өгүүлэхүй доорхи онцлогтой. Үүнд,

- Эхийн өгүүлэхүй мэдээлэн таниулах, ухуулан сэнхрүүлэх хоёр зорилгыг агуулж байдаг.

- Эхийн өгүүлэмжид шинжлэх ухааны нэр томъёо, бичиг баримтын тогтмол үг хэллэг, нутгийн аялгууны болон хувь хүний өвөрмөц дуудлагат үг тэргүүтнийг хязгаарлах боломж бага байдаг.

- Эхийн өгүүлэхүйг утга, агуулгаар нь мэдээний, сурвалжлагын, сурвалжилсан ярианы, тайлан мэдээний, тайлангийн, ярилцлагын, шуурхай ярилцлагын, асуулт хариултын, байцаал(асуулга) – ын, биеийн байцаалын, санал асуулгын, тайлбарын, үзлэг(хяналт)-ийн, голч тоймын, тоймын, уучлалын, зөвлөгөөний, ухуулгын, эмгэнэлийн мэдээний гэх мэт зүйлтэй **шүүмжлэлт бус нийтэлгээний эхийн өгүүлэхүй**; захидлын, сэтгэгдлийн, дурсамжийн, өгүүллийн, эсээний, шүүмжийн, тэмдэглэлийн, сурвалжилсан тэмдэглэлийн, тэмдэглэсэн сурвалжлагын, шалгарууллын, эрэл хайгуул(эрэн сурвалжлахуй)-ын, баримжааллын, хувилбарын, туршилтын, найрууллын, шог найрууллын, хочлолын, элэглэлийн, шог тайлбарын, нийтлэлийн, харуулсын үгийн гэх мэт зүйлтэй **шүүмжлэлт нийтэлгээний эхийн өгүүлэхүй** гэж ангилах боломжтой байдаг.

- Шүүмжлэлт бус эхийн өгүүлэхүйд тоочимж, тайлбарламж давамгайлж байдаг бол шүүмжлэлт эхийн өгүүлэхүйд хүүрнэмж, эргэцүүлэмж давамгайлж байдаг.

- Шүүмжлэлт бус эх дундаж зэргийг илтгэсэн ерийн өгүүлэхүйтэй байдаг бол шүүмжлэлт эх өгүүлэхүйн дээд юм уу доод зэргийг илтгэсэн яруу өгүүлэхүйтэй байдаг.

- Эхийн яруу өгүүлэхүй хошин, хошин бус өнгө аястай байж болно.

- Яруу өгүүлэхүйт нийтэлгээ урансайхны зохиолын эхэд ойр байдаг бол ерийн өгүүлэхүйт нийтэлгээ бичиг баримтын болон шинжлэх ухааны зохиолын эхэд ойр байдаг.

3. Урансайхны эхийн өгүүлэхүй доорхи онцлогтой. Үүнд,

- Эхийн өгүүлэхүйг зохиолч, уран бүтээлч нэр авьяас билгээрээ бүтээж, баяжуулж байдаг.

- Өгүүлэхүйн ямар аргыг хэрхэн хэрэглэх, яаж бүтээн туурвихыг урьдчилан тогтоож журамлах боломжгүй байдаг.

- Эхийн өгүүлэхүй шинжлэх ухааны болон урансайхны эхийн өгүүлэхүйн хосолмол шинжтэй судалгааны зохиолын өгүүлэхүй; юм, үзэгдлийн оршил хувирлын дүр зураг, хүний ааш зан, авир төрх, амьдрал байдал, явдал суудал тэргүүтнийг одоо цагийн хэмжээс дотор дүрслэн үзүүлэх зорилгоор туурвисан жүжгийн зохиолын өгүүлэхүй; гурван цагийн орчил дундахь сав, шим ертөнцийн юм, үзэгдлийн оршил хувирлын дүр зураг, хүний ааш зан, авир төрх, амьдрал байдал, явдал суудал тэргүүтнээс өөрт тусан үүдсэн ойлголт ухаарал, сэтгэгдэл төрөгдөл, бодрол бясалгалын үр дүн, сэтгэлийн чиг хандлагыг өчин илэрхийлэх байдлаар уран яруу шүлэглэн өгүүлж бүтээсэн уянгын зохиолын өгүүлэхүй; гурван цагийн орчил дундахь сав, шим ертөнцийн юм, үзэгдлийн оршил хувирлын дүр зураг, хүний ааш зан, авир төрх, амьдрал байдал, явдал суудал тэргүүтнийг тал бүрээс тусган илэрхийлж, дэлгэрэнгүй дүрслэн зураглаж хүүрнэхдээ хэлний хэрэглүүрийг чадамгай бөгөөд зоригоор ашиглаж, залган өгүүлж бүтээсэн түүлийн зохиолын өгүүлэхүйгээс бүтнэ.

- Судалгааны зохиолын өгүүлэхүйд дүрийн шинжлэл буюу бүтэц, жүжгийн зохиолын өгүүлэхүйд баймж буюу явдал, туулийн зохиолын өгүүлэхүйд юм, үзэгдлийн хувирал хөгжил буюу өгүүлэмж, уянгын зохиолын өгүүлэхүйд дүрслэл буюу зохиомж чухал байдаг.

Гурав. Ухуулан сэнхрүүлэхүйн харилцах үйлд бүх төрлийн өгүүлэхүйгээр илэрсэн уриалга, сонгуулийн болон бараа бүтээгдэхүүний сурталчилгаа, зарим шашны номлол зэрэг багтдаг бөгөөд энэ харилцах үйлийн жинхэнэ мөн чанар мянга мянган хүний сэтгэл оюуныг нэгэн эгшинд эзэмдэн дагуулах их эрчимд оршино.

Ухуулан сэнхрүүлэхүйн харилцах үйл өмч хөрөнгө, нэр төр, эрх ашгаа хамгаалах, маргаан мэтгэлцээнд ялахын тулд нотолгоог зөв бүрдүүлэх ухаан, улс төрийн үзэл суртал, зарим шашны номлолыг дамжуулах гол хэрэгсэл, эх орноо хамгаалахад эр цэрэг, ард иргэнээ урамшуулан зоригжуулж уриалан дуудаж босгох зэвсэг болох зэргээр түүхийн цаг үе бүхэнд тодорхой үүрэгтэйгээр оршиж, нийгмийн оюун санааны хөгжилд төрөл бүрээр нөлөөлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд бизнесийн, хэвлэл нийтэлгээний, шашны, улс төрийн гэх мэт салбар чиглэлээр ихээхэн хөгжиж байна.

Ухуулан сэнхрүүлэхүйн харилцах үйл итгүүлэн үнэмшүүлэх, ятган ухуулах үндсэн зорилготой бөгөөд өгүүлэн буй юмын учир шалтгааныг үндэслэлтэй, үнэн зөв гаргахын тулд баталгаа нотолгоо, жишээ баримтанд тулгуурлан эерэг, сөрөг талыг тэгш харгалзан дүгнэх чухал шаардлагатай ч, үүгээр үл хязгаарлан, харилцах үйл, ялангуяа, ухуулан сэнхрүүлэхүйн харилцах үйлийг сэтгэл татахуйц уран яруу хэллэг, үүтгэгдэх талд хандсан чин сэтгэлийн гэрэл гэгээ жинхэнэ ёсоор амилуулдгийг мартаж болохгүй. Түүнчлэн, ухуулан сэнхрүүлэхүйн харилцах үйл, тухайлбал, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгааг “. . . сэтгэлзүй, бэлгэдлийн цогц тогтолцоо, итгүүлэн үнэмшүүлэх зорилтот өвөрмөц харилцаа . . . амин сүнс нь хэрэглэгчийн сэтгэлзүй, нийгэмч мөн чанарыг санаа бодолд нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний байр суурь, дүр төрх болгон төлөвшүүлэх явдал” (Болд - Эрдэнэ. 2001)¹⁶ гэж үздэг харь хэл, сэтгэлгээтний гүн ухаан, эш онол, үзэл баримтлалд маш болгоомжтой хандаж, “. . . ёс суртахуунд үл нийцсэн . . . Монгол хүний эрхэмлэн

¹⁶ Б.Болд-Эрдэнэ (2001), Реклам: Харилцаа, сэтгэлзүй, бэлгэдэл, УБ.

дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчсөн . . .”(Монгол Улсын хууль.2002.)¹⁷ ухуулга, сурталчилгаанаас ямагт зайлсхийн, Дорнодахины Гүн ухаан, түүний дотроос Бүддагийн ариун суртал(шашин) - ын номд хүнийг бие, хэл, сэтгэл гурван ухагдахууны нэгдлээр тодорхойлж, түүний нүгэл, буяныг биеийн 3; хэлний 4; сэтгэлийн 3 үйлээр хэмжин ялгаж, ингэхдээ сэтгэлийг маш чухалчлан, “Үнэн эрдэмтэн эс омогловч бусдаас дээр явах. Өчүүхэн муу хүн омогловч үл дээрдэх. Үнэхээр сайн эрдэнийг эс магтавч үнэ олох. Үтэл чулууг магтавч үнэд үл хүрэх(Сүбашидээс)” хэмээн сургасны гүн нарийн утгыг сайтар тунгааж, марталгүй даган мөрдөх хэрэгтэй юм. Учир нь, ашиг орлого олох хонжихын шуналд хөтлөгдөн, бусдыг хуурч мэхлэх гэгч хүнд их нүгэл бөгөөд аливаа хүн зөвхөн буяны үрээр л ашдын амгалан жаргаланг олдог жамтайг үе үеийн төгс гэгээрсэн мэргэд айлдан айлдаж, өөрийн биеэр үлгэрлэн үзүүлсээр ирсэн билээ.

НОМЗҮЙ

- Б.Болд-Эрдэнэ (2001), Реклам: Харилцаа, сэтгэлзүй, бэлгэдэл. УБ.
Бурхан Багшийн сургаал (1996), Токио.
Бүддагийн шашин, соёлын тайлбар толь (2000), УБ.
Гуравдугаар Далай Лам. Тунгаамал алтан (2003), УБ.
Т.Дорждагва (2002), Соёлын философи (түүхэн товчоон) УБ.
С.Дулам (2004), Дорнодахины уранзохиолын үүд.УБ.
Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл (1968), 2-р дэвтэр. УБ.
Монголын нэвтэрхий толь II (2000), УБ.
Монгол Улсын хууль (2002), Зар сурталчилгааны тухай. УБ.
Б.Ринчен (1991), Хэлээ хайрлан энхрийлж, үгний боловсролыг эрхэмлэе. “Марк Твений минь махыг нь идэж дээ . . .”, УБ.
Ц. Сүхбаатар (2006), Найруулгазүйн судалбар. УБ.
Философийн толь (1990), УБ.
Л.Хүрэлбаатар (2002), Судар шастирын билиг. УБ.
Ф.Энгельс, Мич хүн болоход хөдөлмөрийн гүйцэтгэсэн үүрэг, “К.Маркс. Ф.Энгельс. Түүвэр зохиол. 3-р боть”.

RESUME

Given article is devoted for the analysis structure of mentality of Mongols, as expression external and a private world of knowledge. It is known, that progress of mentality occurs owing to influence of two forces – constantly extending knowledge of the world and laws of knowledge of the world, that is consists in reflection of cumulative and gnosiological functions of language and grows out dynamical processes of mastering and transformation of knowledge. Mentality - it is a mentality, attitude, the spiritual mood, inherent in group. The mentality of Mongols defines mood and a vital position Mongols.

Communication - a specific form of human interaction for the transfer of information from one person to another, carried out by means of language and other sign systems.

¹⁷ Монгол Улсын хууль (2002), УБ, Зар сурталчилгааны тухай.